

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2026/014/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Ахлах аудитор: Утас: 7036-3036	Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ц.Отгонбаяр Цахим хаяг: <a href="mailto:Otgonbayrts@audit.gov.mn">Otgonbayrts@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2026 он	Аудитор: Утас: 7036-2442	Р.Отгонжаргал Цахим хаяг: <a href="mailto:Otgonjargalr@audit.gov.mn">Otgonjargalr@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.23 № СА-2026/014/НА-СА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Г.БААСАНСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар болон санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд илэрсэн дараах зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 173,426.0 мянган төгрөгөөр тасалсан,

3

4326050349

- Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 7 ажилтанд нийт 3,779.0 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон,
- Батлагдсан төсвийг зардлын бүлэг, арга хэмжээ хооронд гүйлгэн 1,145.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансаар иргэдээс 23,100.0 мянган төгрөгийн хандивын орлого төвлөрүүлж, баяр наадмын зардалд зарцуулсан байна.

#### **Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг**

Орхон сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “2025 оны төсөв батлах тухай” 32 дугаар тогтоолоор 898,322.0 мянган төгрөгийн татварын орлого, 116,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого нийт 1,014,332.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 840,906.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 17.1 хувиар тасалсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын төсөв болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 7 төсөл, арга хэмжээнд 595,501.7 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 504,641.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 90,860.2 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд Орхон сумын Засаг дарга нь 4 зорилт, 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 87.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>663,575.56</b>	<b>499,778.33</b>
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	525,227.28	291,288.92
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	101,867.28	177,034.48
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	36,481.00	31,454.93
5	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>3,062,786.18</b>	<b>3,818,125.52</b>
6	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>12а, 12б, 12в</b>	<b>3,062,786.18</b>	<b>3,818,125.52</b>
7	Биет хөрөнгө		3,038,789.29	3,774,344.25
8	Биет бус хөрөнгө	13	23,996.89	43,781.26
9	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>3,726,361.74</b>	<b>4,317,903.85</b>
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР		39,474.23	76,143.59
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		39,474.23	76,143.59
12	Өглөг		39,474.23	76,143.59
13	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,686,887.52</b>	<b>4,241,760.26</b>
14	Засгийн газрын хувь оролцоо		3,686,887.52	4,241,760.26
15	Засгийн газрын оруулсан капитал		262,048.72	262,048.72
16	Хуримтлагдсан үр дүн		3,299,210.67	3,854,083.42
17	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		125,628.13	125,628.13
18	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>3,726,361.74</b>	<b>4,317,903.85</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>2,583,735.62</b>	<b>3,113,742.51</b>
2	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>802,102.63</b>	<b>730,657.91</b>
3	Орлогын албан татвар		385,355.30	386,223.28
4	Хувь хүний орлогын албан татвар		425,950.51	425,834.67
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-40,595.21	-39,611.39
6	Хөрөнгийн албан татвар		157,176.23	180,626.10
7	Бусад татвар, төлбөр, хураамж		259,571.1	163,808.53
8	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>621,577.94</b>	<b>2,383,084.60</b>
9	Тусламжийн орлого		0.00	993,508.36
10	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>1,160,055.04</b>	<b>0.00</b>
11	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>1,633,502.50</b>	<b>2,007,964.89</b>
12	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,609,552.90</b>	<b>1,797,198.26</b>
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,536,035.21	1,787,953.04
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		595,753.06	828,741.94
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		75,301.03	102,696.25
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		425,997.70	437,585.12
17	Хангамж, бараа материалын зардал		51,385.50	73,331.49
18	Норматив зардал		0.00	5,505.00
19	Эд хогшил, урсгал засварын зардал		38,112.5	75,983.71

20	Томилолт, зочны зардал		5,270.00	10,225.60
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		43,675.17	37,896.67
22	Бараа үйлчилгээний бусад зардал		300,540.26	215,987.26
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		73,517.7	9,245.22
24	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>23,949.6</b>	<b>210,766.62</b>
25	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>950,233.11</b>	<b>1,105,777.62</b>
26	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>468,562.09</b>	<b>550,904.88</b>
27	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>		<b>-468,562.09</b>	<b>-550,904.88</b>
28	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>481,671.02</b>	<b>554,872.75</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,214,037.90</b>	<b>0.00</b>	<b>3,214,037.90</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-8,821.40	0.00	-8,821.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,205,216.50	0.00	3,205,216.50
4	Тайлант үеийн үр дүн	481,671.02	0.00	481,671.02
5	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,686,887.52</b>	<b>0.00</b>	<b>3,686,887.52</b>
6	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>3,686,887.52</b>	<b>0.00</b>	<b>3,686,887.52</b>
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,686,887.52	0.00	3,686,887.52
8	Тайлант үеийн үр дүн	554,872.75	0.00	554,872.75
9	<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>4,241,760.26</b>	<b>0.00</b>	<b>4,241,760.26</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,185,850.10</b>	<b>2,373,160.21</b>
<b>2</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>802,102.63</b>	<b>730,657.91</b>
3	Орлогын албан татвар	385,355.30	386,223.28
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-40,595.21	-39,611.39
5	Хөрөнгийн албан татвар	157,176.23	180,626.10
6	Бусад татвар, төлбөр, хураамж	259,571.10	163,808.53
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,435.25	28,001.64
8	Газрын төлбөр	206,418.95	130,151.51
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	33,716.90	5,655.38
<b>10</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>195,873.69</b>	<b>1,642,502.30</b>
11	Нийтлэг татварын бус орлого	195,873.69	219,785.15
12	Тусламжийн орлого	0.00	995,329.44
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	427,387.70
<b>14</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,187,873.78</b>	<b>0.00</b>
<b>15</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,377,738.56</b>	<b>1,718,690.43</b>
<b>16</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,377,738.56</b>	<b>1,718,690.43</b>
<b>17</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,304,220.86</b>	<b>1,699,916.92</b>
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	594,810.26	828,286.31
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,649.78	102,696.25
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	425,997.7	437,381.62
21	Хангамж, бараа материалын зардал	49,516.97	63,929.75
22	Норматив зардал	0.00	5,292.00
23	Эд хогшил, урсгал засварын зардал	38,112.5	90,700.77
24	Томилолт, зочны зардал	5,144.00	10,225.60
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,770.24	37,478.54
26	Бараа үйлчилгээний бусад зардал	70,219.41	123,926.08
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,517.7	18,773.51
<b>28</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>808,111.54</b>	<b>654,469.78</b>
<b>29</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>498,104.69</b>	<b>715,408.14</b>
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	498,104.69	715,408.14
31	Дотоод эх үүсвэрээр	498,104.69	715,408.14
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-498,104.69	-715,408.14
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	173,000.00
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	-173,000.00
<b>35</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>310,006.85</b>	<b>-233,938.36</b>
<b>36</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>215,220.44</b>	<b>525,227.28</b>
<b>37</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>525,227.28</b>	<b>291,288.92</b>

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,899,824.10</b>	<b>2,035,662.96</b>	<b>864,161.14</b>	<b>70.2</b>
<b>21</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,806,992.00</b>	<b>1,671,288.57</b>	<b>135,703.43</b>	<b>92.5</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	861,567.80	827,771.81	33,795.99	96.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,132.60	102,696.25	19,436.35	84.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	479,090.10	437,381.62	41,708.48	91.3
2104	Хангамж, бараа материалын зардал	58,813.00	52,329.75	6,483.25	89.0
2105	Норматив зардал	9,878.40	5,292.00	4,586.40	53.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,289.00	86,309.31	13,979.69	86.1
2107	Томилолт, зочны зардал	15,350.00	10,225.60	5,124.40	66.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,269.20	37,478.54	22,790.66	62.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,601.90	90,215.96	9,385.94	90.6
21090	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,058.80	12,342.50	2,716.30	82.0
	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	2,035,662.96	-	-
	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-	2,035,662.96	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40,490.00</b>	<b>9,245.22</b>	<b>31,244.78</b>	<b>22.8</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,490.00	9,245.22	31,244.78	22.8
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>857,001.70</b>	<b>364,374.39</b>	<b>492,627.31</b>	<b>42.5</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>195,340.40</b>	<b>-</b>	<b>195,340.40</b>	<b>-</b>
<b>23000</b>	<b>3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл</b>	<b>195,340.40</b>	<b>173,000.00</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>1,462,055.60</b>	<b>(235,759.44)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(1,462,055.60)</b>	<b>235,759.44</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>7</b>	<b>3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(1,462,055.60)</b>	<b>235,759.44</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>525,227.28</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>291,288.92</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>6</b>	<b>6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>25.00</b>	<b>20.00</b>	<b>-</b>	<b>80.0</b>
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	4.00	4.00	-	100.0
61000	6.1.01 Төсвийн байгууллага	4.00	4.00	-	100.0
62	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	20.00	-	80.0
620001	6.2.01 Удирдах ажилтан	<b>7.00</b>	7.00	-	100.0
620002	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	16.00	11.00	-	68.8
620004	6.2.04 Гэрээт ажилтан	2.00	2.00	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	59,744.4
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,744.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,216.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,216.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,216.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514.5
210101	Үндсэн цалин	514.5
2104	Хангамж, бараа материалын зардал	11,600.0
210401	Бичиг хэрэг	2,200.0
210402	Тээвэр, шатахуун	9,400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,391.5
210604	Урсгал засвар	4,391.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,710.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,710.1
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	9,528.3
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(9,528.3)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(9,528.3)

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **232,867.4** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 201,350.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 31,517.4 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 201,350.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 16,335.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

#### **Төсвийн төвлөрүүлэн захирагч:**

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 173,426.0 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Төсвийн орлогын төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авч, орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

### **Сумын ЗДТГ:**

2. Бичиг хэргийн зардлаас БҮТЭЗ-д 155.0 мянган төгрөгийн, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас БҮТЭЗ-д 260.0 мянган төгрөгийн, томилолтын зардлаас нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд 630.0 мянган төгрөг нийт 1,045.0 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *“Зардлын эдийн засгийн ангиалал ашиглах заавар”*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансаар иргэдээс 23,100.0 мянган төгрөгийн хандивын орлого төвлөрүүлж, баяр наадмын зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь *“Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно.”*, 25.2.1 дэх *“эмнэлгийн үйлчилгээ”*, 25.2.2 дахь *“бүх шатны боловсролын үйлчилгээ”*, 25.2.3 дахь *“соёлын үйлчилгээ”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 7 ажилтанд нийт 3,779.0 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Үүнд:

### **Сумын ЗДТГ,**

- Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 6 ажилтанд 3,609.7 мянган төгрөгийн цалинг давхардуулсан,

### **Сумын ИТХ,**

- Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 1 ажилтанд 169.3 мянган төгрөгийн цалинг давхардуулсан,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх *“Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

### **3.2 Зөвлөмж**

#### **Сумын ЗДТГ:**

##### **1. Бараа материалтай холбоотой:**

Илрүүлэлт: Тайлант онд зарцуулсан **31,517.4** мянган төгрөгийн шатахууны тайланд спидометрийн заалтыг зөрүүтэй тусгасан, жолооч хүлээн авсан шатахууны хэмжээгээр зарцуулалтыг гаргасан, нягтлан бодогч ажил гүйлгээг хянаж баталгаажуулаагүй, хэтрэлт хэмнэлтийг тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөр тооцоо болон ажил гүйлгээг хянаж баталгаажуулсны үндсэн дээр гүйцэтгэж байх зөвлөмж хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	173,426.0	-	-	1	173,426.0	-	-
ЗДТГ	4	59,272.1	-	-	3	27,754.7	1	31,517.4
ИТХ	1	169.3	-	-	1	169.3	-	-
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>232,867.4</b>	-	-	<b>5</b>	<b>201,350.0</b>	<b>1</b>	<b>31,517.4</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хоцроосон байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								